



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 32

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 54,090,486 /тавин дөрвөн сая ерэн мянга дөрвөн зуун наян зургаа/ төгрөгийн балансын үнэтэй 42,968,924 /дөчин хоёр сая есөн зуун жаран найман мянга есөн зуун хорин дөрөв/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 75 хүүхдийн дотуур байрны барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2 Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Дэлгэрсайхан)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг худалдан борлуулж, орлогыг аймгийн хөрөнгө худалдсаны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх;

2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталснаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн  
32 дугаар тогтоолын хавсралт



Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн актлах барилгын мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалт ад орсон он	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
			хэмжих нэгж	Биет хэмжээ						
1	75 хүүхдийн Дотуур байр	Дотуур байр	хүүхэд	75	1978	44	54,090,486.38	11,121,562.40	42,968,923.98	МХГ-ын ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан
<b>Дүн</b>							<b>54,090,486</b> /тавин дөрвөн сая ерэн мянга дөрвөн зуун наян зургаа/ төгрөг		<b>42,968,924</b> /дөчин хоёр сая есөн зуун жаран найман мянга есөн зуун хорин дөрөв/ төгрөг	